



Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль

2024 оны 9 сарын 25

Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн сургалт нь оролцогчдийг хүний хувийн мэдээлэл хамгаалахад практикт тулгамдаж буй хиймэл оюун ухаан, хөдөлмөрийн харилцаа болон Европын холбооны хувийн мэдээллийг хамгаалах хууль (GDPR) зэрэг асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар өргөн мэдлэг, практик ойлголтоор хангах зорилготой. Мөн энэхүү сургалтаар мэдээллийн нууцлалыг хангах нь компаниудын Байгаль орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ) үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж болох талаар авч үзнэ.

Хэнд зориулагдсан бэ?

Энэхүү сургалт нь хүний хувийн мэдээлэлтэй харьцдаг өргөн хүрээний мэргэжилтнүүдэд зориулагдсан бөгөөд үүнд дараах багтана:

- Компанийн удирдлагууд
- Мэдээлэл технологи хариуцсан захирал
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах мэргэжилтэн
- Маркетингийн менежер, мэргэжилтэн
- Хүний нөөцийн менежер, мэргэжилтэн
- Компанийн хуульч
- Мэдээлэл технологийн мэргэжилтэн
- Компаенсын мэргэжилтэн
- БОНЗ-ын мэргэжилтэн болон
- Хувийн мэдээлэлтэй байнга харьцдаг ажилтнууд.

Сургалтын хөтөлбөр

- Хувийн мэдээлэл хамгаалах бодлого боловсруулах, мэдээлэл боловсруулах гэрээ байгуулах, болон хүний оролцоогүй цахим хэлбэрээр мэдээлэл боловсруулалт хийх зэрэг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн гол анхаарах асуудлууд;
- Хөдөлмөрийн харилцааны явцад хүний хувийн мэдээллийг хамгаалах;
- Хиймэл оюун ухааны хэрэглээ ба түүний хууль зүйн асуудлууд: хууль эрх зүйн болон ёс зүйн ерөнхий хүрээ;
- Хувийн мэдээллийн зөрчил түүнийг арилгах хариу арга хэмжээний төлөвлөгөө, сайн туршлага;
- Мэдээлэл хамгаалах нөлөөлөх байдлын үнэлгээ гүйцэтгэх;
- Хил дамнасан мэдээлэл дамжуулалт, мэдээллийг нутагшуулах асуудал;
- Дүрс бичлэгийн систем ашиглах хуулийн шаардлага, бизнесийн орчинд тулгарч буй асуудлууд;
- Европын холбооны Хувийн мэдээлэл хамгаалах хууль: Монгол Улсад үйлчлэх үү? хамрах хүрээтэй холбоотой бусад асуудлууд; мөн
- Шинэ чиг хандлага, сайн туршлагууд: мэдээллийн нууцлалын БОНЗ-д нөлөөлөх байдал, мэдээллийн засаглал, комплайнс

Сургагч багш нар

Батзулын Амарбат

Менежер,
Татвар, хуулийн үйлчилгээ



Боловсрол болон мэргэжлийн туршлага

Ажлын 5+ жилийн туршлагатай бөгөөд хүний хувийн мэдээлэл болон мэдээлэл технологийн эрх зүйгээр мэргэшсэн. Тэрээр Германы Гёттингений их сургуульд хувийн мэдээлэл хамгаалах эрх зүйгээр магистрын зэрэг хамгаалсан. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй.

Отгонтогтоолын Мөнхнасан

Ахлах хуульч,
Татвар, хуулийн үйлчилгээ



Боловсрол болон мэргэжлийн туршлага


Хүний хувийн мэдээлэл хамгаалах дотоод үнэлгээ хийх, хувийн мэдээллийг хамгаалах асуудлаар хууль зүйн зөвлөгөө өгч байсан туршлагатай. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй.

Сургалтын мэдээлэл

Сургалтын өдөр: 2024 оны 9 сарын 25
Бүртгэл: 8:45
Хугацаа: 9:00 – 13:00
Хэл: Монгол хэл
Байршил: Улаанбаатар ЗБ
Сертификат: PwC сертификат

Сургалтын агуулга

- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн гол анхаарах асуудлуудыг хэлэлцэх;
- Хил дамнаж мэдээлэл дамжуулах, мэдээллийг нутагшуулах асуудлын талаар туршлага хуваалцах;
- Хувийн мэдээллийг хамгаалах эрх зүйн орчны практик асуудлуудыг хуваалцах;
- Байгууллага хувийн мэдээллийг хэрхэн зохицуулах талаар мэдээлэл өгөх;
- Мэдээллийн нууцлалыг хангах нь компаниудын БОНЗ-ын үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж болох талаар ярилцах;
- Хувийн мэдээлэлтэй ажиллах практик зөвлөмж, сайн туршлагыг хуваалцах.



Сургалтын төлбөр

400,000₮ + НӨАТ

Холбоо барих мэдээлэл

+976 7000 9089
mn_academy@pwc.com

Бусад сургалтуудын талаарх мэдээллийг та **ЭНД** дарж авах боломжтой.